



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/917

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид бүртгэн
авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх заалт, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 77 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын Дээд шүүхийн 2023 оны 15 дугаар тогтоолыг үндэслэн нийт 157,140,000.00 (нэг зуун тавин долоон сая нэг зуун дөчин мянга) төгрөгийн өртөг бүхий хавсралтад заасан хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2. Энэ захирамжийн 1-д заасан хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ (Г.Мөнхзул)-т үүрэг болгосугай.


3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
 07 дугаар сарын 31 өдрийн
 4/017 дугаар захирамжийн
 хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Байршил		Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ	Гэрчилгээ
1	36-р байрны 1-2 тоот өрөө	Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо, 16 дугаар хороолол, 36-р байр 1-2 тоот		м.кв	38,5 мкв	147,070,000.00	Ү-2204071176
	Барилга байгууламжийн дүн					147,070,000.00	
№	Хөрөнгийн нэр	Улсын дугаар	Арлын дугаар	Гүйлт	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ	
2	Тоёота приус-20	26-70 УНЛ	NHW200113258	256,994 км	1	10,070,000.00	
	Тээврийн хэрэгслийн дүн					10,070,000.00	
НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ДҮН						157,140,000.00	